

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 10 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөрийн эрүүл ахуйн албаны тухай” 161 дүгээр конвенц болон “Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81 дүгээр конвенцийг Монгол Улс соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг УИХ-ын Аюулгүй байдлын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэв.

УИХ-аас батлан гаргасан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийг дагалдаж гарах журмуудын төсөл боловсруулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хуваарьт өөрчлөлт оруулж жижиг зээлийн эх үүсвэрийг 1400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн банк болон банк бус санхүүгийн байгууллагад жижиг зээлийн санхүүжилтэд нэмж байршуулав. Ингэснээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас банк болон банк бус санхүүгийн байгууллагад жижиг зээлийн зориулалтаар 2008 онд байршуулсан хөрөнгийн хэмжээ 8400.0 сая төгрөг болж нэмэгдэн, жижиг зээлээр ашиглагдаж байгаа нийт зээлийн үлдэгдэл 2008 оны эцэст 18180.0 сая төгрөг болох юм. Жижиг зээлийн санд 1400.0 сая төгрөг нэмж байршуулснаар 1150 орчим ажлын байр бий болох тооцоо гарч байна.

Харин ажил олгогчдыг дэмжих арга хэмжээний үйлдвэрлэл дээрх сургалтын зардлаас үлдэхээр тооцсон 100.0 сая төгрөгийг гадаадаас ажиллах хүч олноор авч байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран гадаадын иргэд авч ажиллуулж байгаа ажлын байранд дотоодын ажилтнуудыг бэлтгэх, үйлдвэрлэл дээр сургах арга хэмжээг 2008 онд салбарын яамд, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор зохион байгуулж, 100.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна. Уг асуудлаар салбарын яамд, гадаадаас ажиллах хүч авч байгаа томоохон аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран уулзалт, ярилцлага зохион байгуулав. Уулзалтаар барилга, зам, хөдөө аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэр, эрдэс баялгийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай томоохон компаниудтай гэрээ байгуулж ажилгүй иргэдийг ажлын байран дээр нь сургалтанд хамруулж, тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчдод Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас сургалтын зардлыг нь санхүүжүүлэх ажлыг зохион байгуулахаар ярилцлаа.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 116 дугаар тушаалаар байгуулав.

“Төрийн албаны тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, “Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” УИХ-ын болон Засгийн газрын тогтоолын төсөл, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай”, “Төрийн албан хаагчид олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал, урамшил, бусад тусламж болон ажилласан жил тооцох тухай” Засгийн газрын тогтоолын төслүүдийг Засгийн газарт өргөн барихаар бэлтгээд байна.

Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, БНСУ-ын Хөдөлмөрийн яамны хооронд байгуулсан “БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй Монгол Улсын иргэнийг бүртгэх ажлыг зохион байгуулах талаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаал гаргав. Уг бүртгэлийн ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, “Гадаадад ажиллах хүч илгээх төв” ХХК-ийн хамтран ажиллах гэрээний үндсэн дээр “Гадаадад ажиллах хүч илгээх төв”, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүд зохион байгуулах юм. Бүртгэлийн ажлыг зохион байгуулах Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн ажилтнуудад зориулсан семинарыг зохион байгуулж, бэлтгэл ажилдаа ороод байна.

УИХ-д өргөн бариад байсан “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг эгүүлэн авч, шинэчилсэн найруулгаар боловсруулахаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулаад байна.

Монгол Улсын үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулан боловсронгуй болгох, олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх санал боловсруулах ажлын хэсгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 112 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд Нийгмийн даатгалын тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудад үнэлгээ хийх, шинэчлэлийн бодлогын үндэслэл, хувилбарыг тодорхой болгох, холбогдох судалгааг боловсруулах ажлуудыг эхлээд байна. Түүнчлэн

Монгол Улсын Засгийн газраас 2008-2012 онд тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд зарцуулагдах нийт хөрөнгийн тооцоо судалгааг гаргалаа.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, “Тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар батлуулж, яамдын санал авч байна.

“Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл боловсруулж байгаатай уялдуулан Монгол Улсын ударник цол тэмдгээр шагнагдсан иргэдийн тооцоо судалгааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас авч, Монгол Улсын ударник цол тэмдгийн талаар судалгаа хийгээд байна.

“Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, тус хуульд шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд 300 мянган төгрөгийг нэг удаа олгох заалт нэмэхээр холбогдох тооцоо судалгаа хийж, үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулав.

Швейцар Улсын Женев хотноо болсон НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хорооны ээлжит хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын тайлан илтгэлийг хэлэлцүүлэв.

Хүүхэд хамгаалал болон хүн худалдаалах асуудлаар нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах асуудлаар Монголын нийгмийн ажлын багш сурагчдын холбоо, Олон улсын Хүн амын шилжин суурьшлын байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж үйл ажиллагааг эхлүүлэв.

Санамж бичгийн хүрээний үйл ажиллагааг энэ оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн 2009 оны 12 дугаар сарыг дуустал гурван үе шаттайгаар нийслэл, орон нутагт хэрэгжүүлж, 30 сургагч багш бэлтгэн, нийслэл, орон нутгийн сургууль, халамжийн бүхий л нийгмийн ажилтнуудыг хамарсан сургалт зохион байгуулж, Олон улсын Хүн амын шилжин суурьшлын байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сангаас хамтран 150 000 орчим ам.доллар зарцуулах юм.

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн чиглэлээр мэдээллийн бааз бүрдүүлэх ажлын хүрээнд нийгмийн хамгааллын салбарын 2000-2007 оны тоон мэдээллүүдийг нэгтгэн цуглуулах ажил хийгдэж дуусаад байна. Энэхүү мэдээллийн санд Нийгмийн даатгалын статистикийн бүх үзүүлэлтүүд, Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтыг зардлын төрөл тус бүрээр аймаг бүс нутгаар задлан нэгтгэж, Хүн амын чиглэлээр жилийн эцсийн хүн ам, өрхийн тоо, хүн амын өсөлтийн хувь, төрөлтийн нийлбэр болон ерөнхий коэффициент, дундаж наслалт, 1000 хүн амд ногдох гэрлэлт ба гэр бүл цуцлалт, жендэрийн хөгжлийн индекс, хүний хөгжлийн индекс, нэг хүнд ногдох ДНБ, хүн ам зүйн нягтшил, хүн ам зүйн ачаалал, нийт хүн амд хөдөөгийн хүн амын эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүдийг аймгаар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслийн аймаг, орон нутагт зарцуулж буй хөрөнгийн талаар мэдээлэл болон хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүдийг нэгтгэлээ. Дээрх мэдээллийн баазыг бий болгосноор нийгмийн хамгааллын салбарын үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх чухал ач холбогдолтой болох юм.

Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж, салбарын хэмжээнд хийх ажлын төлөвлөгөө гарган ажиллав.

Нээлттэй хаалганы өдрийг “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдээс санал авах өдөр” уриан дор олон нийтийг өргөн хүрээнд хамруулах хэлбэрээр зохион байгуулав. Аймгууд нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээг 10 дугаар сарын 17-20-нд зохион байгуулж, иргэдэд мэдээлэл хүргэх, санал бодлыг нь сонсох зэргээр төрийн үйлчилгээ үзүүлэх олон хэлбэрийн ажлыг зохион байгууллаа. Нийслэлд нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг 10 дугаар сарын 20-нд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, дүн мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар: Тайлант хугацаанд Халамжийн тэтгэвэрт нийт **49180** иргэн хамрагдаж тэдэнд **15987.7** сая төгрөгийг олгосон байна.

Нөхцөлт мөнгөн тэтгэмж :

- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа 6986 иргэнд 1293.0 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 6775 иргэнд 963.0 сая төгрөг,

- Байнгын асаргаа шаардлагатай Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа 1555 иргэнд 218.2 сая төгрөг,
- Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа 522 хүнд 89.2 сая төгрөг,
- Хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа 28 иргэнд 2.6 сая төгрөг,
- Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа 390 хүнд 76.9 сая төгрөг,
- Хүүхэд, төрөл садангүй, ганц бие Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа 94 иргэнд 4.6 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ : Үүнд нийт **11375** иргэн хамрагдаж тэдэнд **802.8** сая төгрөгийг олгосон байна.

- Зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулахад 2464 иргэн хамрагдаж 45.6 сая төгрөг,
- Хөдөлмөр эрхлэж, орлогын эх үүсвэртэй болгоход нь туслах зорилгоор 1127 иргэнийг хамруулж 70.9 сая төгрөг,
- Сэргээн засах үйлчилгээнд 2554 иргэн хамрагдаж 163.9 сая төгрөг,
- Түр байршуулан асрамжлах үйлчилгээнд 1444 иргэнийг хамруулж 107.3 сая төгрөг,
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд 2661 иргэнийг хамруулж 335.4 сая төгрөг,
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж авч байгаа асаргаа, сувилгаа үзүүлж байгаа иргэдэд зориулсан сургалтанд 1125 иргэнийг хамруулж 79.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж : Үүнд нийт 6221 иргэн хамрагдаж 957.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

- Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн цэцэрлэгийн хоолны үнийн хөнгөлөлтөнд 2503 хүүхдэд 90.1 сая төгрөг,
- 3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа олгодог тэтгэмжинд 385 хүүхэд хамрагдаж 27.0 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа олгодог тэтгэмжинд 2027 иргэнийг хамруулж 196.6 сая төгрөг,
- 3 ба түүнээс дээш тооны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа олгодог тэтгэмжинд 268 иргэнийг хамруулж 25.0 сая төгрөг,
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа олгодог тэтгэмжинд 270 иргэн хамрагдаж 108.0 сая төгрөг,
- Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа олгодог тэтгэмжинд 768 өрхөд 511.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилт : Үүнд нийт 1238761 иргэн хамрагдаж 68421.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 946926 хүүхдэд 24936.5 сая төгрөг,
- Шинээр төрсөн 45131 хүүхдэд 4513.1 сая төгрөг,
- Шинээр гэр бүл болсон 24506 өрхөд 12253.0 сая төгрөг,
- Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 80918 эхчүүдэд 12230.6 сая төгрөг,
- Алдар цолтой 4827 ахмадуудад 673.0 сая төгрөг,
- Алдарт эхийн одонтой 131110 эхчүүдэд 8472.0 сая төгрөг,
- Монгол улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын ба гавъяат цолтнуудад төрөөс олгосон нэмэгдэл /Цэргийн тэтгэвэр/-д 5343 иргэн хамрагдаж 5343.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал. Тайлант хугацаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 31.4 мянга, ажилгүйдлийн түвшин 3.0 хувь, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 641 хүнээр, ажилгүйдлийн түвшин 0.1 хувиар буурсан байна.

Ажилгүйчүүдийн хөдөлгөөнийг 2008 оны 10 дугаар 1-ний байдлаар авч үзвэл нийт 43357 ажилгүй иргэд шинээр бүртгүүлж, бүртгэлээс 41432 хасагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 1762 хүнээр, бүртгэлээс хасагдсан ажилгүй иргэдийн тоо 4357 хүнээр тус тус буурсан байна.

Тайлант хугацаанд ажил хайгчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж нийт 48.0 мянга гаруй ажилгүй иргэдийг хамруулсан байна. 2008 оны 10 дугаар 1-ний байдлаар нийт 34077 иргэнийг ажилд зуучлан оруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4157 хүнээр буюу 10.9 пунктээр буурсан байна.

Тайлангийн хугацаанд ажил олгогчдоос нийт 37771 ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 8629-өөр буюу 18.6 пунктээр буурсан байна.

2008 оны 10 дугаар 1-ний байдлаар нийт 12643 ажилгүй иргэнийг мэргэжлийн сургалтад хамруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2284-өөр буюу 15.3 пунктээр буурсан байна. Мөн 11473 ажилгүй иргэнийг нийтийг хамарсан зохион байгуулалттай ажилд хамруулж, түр ажлын байраар хангаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэхүү ажилд 1072.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох зээлийн хүү нөхөн төлөх журам”-ын дагуу банк, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жижиг зээл олгож байна. 2008 оны эхний 9 сарын байдлаар өссөн дүнгээр Хас, Монгол Шуудан, Анод, Капитал, ХААН банкууд, Эрхэс сан, Актив Инвест, Ажилгүйдлийг Бууруулахад Туслах сан, Цэнүж, Бизнес Инвест Девелопмент, Капмон, Үнэнч итгэл, Мастер Инвест, Сити хөгжил, Ситизенс банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан 2252 албан бус хөдөлмөр эрхлэгч, 1459 ажилгүй иргэн, 800 малчин, 137 аж ахуйн нэгж, байгууллагад 7 тэрбум 720.5 сая төгрөгийн зээлийг олгосноор 14033 хүн ажлын байраар хангагдсан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт:

2008-2009 оны хичээлийн жилд эмзэг бүлгийн өрхийн хүүхдэд сургуулийн номын сангаар дамжуулан олгох сурах бичгийн судалгааг гаргав. Мөн нийгмийн эмзэг бүлгийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь ЕБС-д зэрэг суралцдаг өрхийн нэг хүүхдэд хичээлийн хэрэглэл худалдан авах 2008 оны үлдэгдэл хөрөнгөөр нийслэлийн дүүргийн гэр хороололд амьдардаг эмзэг бүлгийн өрхийн бага ангийн зарим сурагчдад хичээлийн хэрэглэл олголоо.

“Хүүхдэд ээлтэй сургуулийн хөгжилд сурагчдын оролцоо” жижиг төслийн тэтгэлэгт уралдааныг 9 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд зарлаж дүгнэлээ. Уралдаанд 144 төслийн санал ирснээс 50 төслийг шалгаруулан батламж, тус бүр 50000 төгрөгийн төслийн санхүүжилтийг олголоо.

НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Боловсролын Их сургуультай хамтран “Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн сургалтын өнөөгийн байдал” судалгааг явуулж, дүнг олон нийтэд танилцуулах уулзалтыг 10 дугаар сарын 8-ны өдөр зохион байгууллаа. Энэ үеэр эрүүл мэндийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын байгууллагууд хамтын ажиллагааны сүлжээ байгууллаа.

БСШУЯ, ЭМЯ, НХХЯ, ХХААХҮЯ, УМХГ-ын төлөөлөл оролцсон “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх зөвлөлдөх уулзалтыг 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтаар “Үдийн цай” хөтөлбөрийн өнөөгийн байдал, түүнд хийсэн хяналт-шинжилгээний дүн, нийслэлийн сургуулиудад хөтөлбөрийн хэрэгжилт ямар байгаа талаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээ, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд байгууллагуудын хамтын оролцоо, үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойллоо.

“Журам батлах тухай” Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолын дагуу 2008-2009 оны хичээлийн жилд магадлан итгэмжлэгдсэн 95 их, дээд сургууль, коллежийн 6200 оюутанд сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламж олголоо.

БСШУ-ы сайдын 2008 оны 15 дугаар тушаалаар батлагдсан “Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хугацааг сунгах, цуцлах ажлыг хянан шийдвэрлэхэд баримтлах заавар”-ын дагуу дээд болон мэргэжлийн сургуулиудын тусгай зөвшөөрөл, улсын бүртгэлийн шинэчилсэн бичилт хийх ажлыг эхлүүллээ.

Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 2008-2009 оны хичээлийн жилд ОХУ-д 160 оюутан, 10 докторант, БНПУ-д 20 оюутан, 2 докторант, БНТУ-д 35 оюутан, 7 магистрант, докторант, Вьетнамд 15 оюутан, Лаосд 3 оюутан, Украинд 2 докторантыг, Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр дотоодын 5 их сургуульд 10 орны 166 иргэнийг суралцуулахаар тус тус шийдвэрлэлээ.

“Казахстан Улсын соёлын өдрүүд”-ийг Улаанбаатар хотноо 10 дугаар сарын 2-5-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр урлагийн тоглолт, гэрэл зургийн болоод түүхийн дурсгалт зүйл, археологийн олдворуудын үзэсгэлэн гарлаа.

Швейцарийн хөгжлийн сангийн 35,0 сая төгрөгийн санхүүжилтээр нийслэлийн 24, 5 дугаар дунд сургуулийн бага ангийн сурагчдыг хамруулсан “Урлаг хүний хөгжилд” төслийг хэрэгжүүлж эхэллээ. Төслийн хүрээнд хүүхдэд бага наснаас нь гоо зүй, урлагийн боловсрол олгох, хэл яриа, танин мэдэхүй, сэтгэхүйг хөгжүүлэх, урлагийг таашаан хүртэх анхан шатны боловсрол олгох чиглэлээр цуврал лекц, сургалтууд явагдана.

“Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үйлгэрчилсэн дүрэм”-ийг баталж, ХБНГУ-ын Элчин сайдын яамтай хамтран “Номын сангийн үйлчилгээний жишиг” сэдэвт сургалтыг зохион байгуулж, төв, орон нутаг, их, дээд сургуулийн 45 номын санчийг хамрууллаа. Энэ нь номын сангийн үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалт, үйлчилгээг “Номын сангийн орчны MNS 5742:2007 стандарт”-д нийцүүлэх, үйлчилгээг олон улсын түвшинд ойртуулахад чиглэж байгаа юм.

Байгаль нийгмийн ухааны шагнал, Технологийн дэвшлийн шагнал, Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны шагналд нэр дэвшүүлэх болзлын дагуу нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч, дүгнэлтийг Засгийн газарт оруулахаар бэлэн болголоо.

“Valorization of R&D” сэдэвт сургалт семинарыг Нэгдсэн Үндэстний Ази-Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комиссын харъяа Ази Номхон далайн технологи дамжуулах төв, Энэтхэг Улсын шинжлэх ухаан, аж үйлдвэрийн судалгааны зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Энэхүү сургалт семинар нь шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлого төлөвлөлтийн асуудлаар манай улсад анх удаа зохиогдож буй олон улсын хурал бөгөөд 70 гаруй эрдэмтэд оролцлоо.

“Зарлагын хязгаар батлах тухай” Засгийн газрын 2008 оны 7 дугаар тогтоолоор Боловсрол, соёл шинжлэх ухааны салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2009 оны төсвийн зарлагын хязгаарыг 489,410,0 сая төгрөг, 2010 оны хязгаарыг 458,209,7 сая төгрөг, 2011 оны хязгаарыг 484,958,5 сая төгрөг байхаар тус тус баталсны дагуу салбарын 2009 оны төсвийн төсөл, 2010-2011 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсрууллаа.

Улсын төсөв, Монгол Улсын хөгжүүлэх сангийн хөрөнгөөр баригдсан цэцэрлэг, сургуулийн 11 шинэ барилгыг хүлээн авч, сургуулийн хичээлийн болон дотуур байр, гал тогоо, цэцэрлэг, сумдын номын сан, соёлын төв зэрэг 200 гаруй байгууллагад сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлээ.

ЕБС, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтны бодит орлогыг нэмэгдүүлэх аргачлал боловсруулах ажлын хэсгээс яамны нэгжийн дарга нарын хуралдаанаар “ЕБС, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд боловсролын шинэчлэлийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд зориулсан урамшуулал олгох журам”-ын төслийн эхний хэлэлцүүлгийг хийлээ.

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Үндэсний аудитын газрын дүгнэлт, судалгаа, зөвлөмж, яамны үйл ажиллагааны өнөөгийн байдал зэрэгт үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны бүтэц, орон тоо, үйл ажиллагааны стратегийн төслийг боловсруулж Засгийн газарт өргөн барилаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын “Нээлттэй мэдээллийн өдөр”-ийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан тусгай хөтөлбөрийн дагуу нэгдсэн арга хэмжээг Мэдээллийн технологийн үндэсний паркт зохион байгууллаа. Энэ өдөр иргэдээс ирүүлсэн зарим гол санал, шүүмжлэлийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарт:

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 220 дугаар тогтоолоор орон нутгийн захиалгаар хөдөө орон нутагт 6 сарын хугацаатай ажиллах нарийн мэргэжлийн эмч нарын хуваарь, тэдэнтэй байгуулах гэрээний загварыг баталж, хуваарилагдсан эмч нарын ажиллах нөхцөлийг хангаж, цалин болон бусад нэмэгдлийг Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын дагуу тооцож олгохыг нарийн мэргэжлийн эмч авч ажиллуулж буй аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, сар бүр олгох нэг сая төгрөгийн урамшууллыг Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” төслөөс санхүүжүүлэхийг төслийн захирал нарт тус тус даалгалаа. Мөн эдгээр эмч нарыг орон нутаг ажиллах гэрээт хугацаа дууссаны дараа тухайн ажлын байранд нь эргүүлэн авч ажиллуулахыг төрөлжсөн эмнэлгийн дарга нарт даалгав.

“Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” төслийн гэрээний холбогдох заалт, төслийг хэрэгжүүлэх удирдамжийн санамж бичгийн 9 дүгээр хавсралт, тус яамны эмч, оюутныг сонгон шалгаруулж сум, сум дундын эмнэлэгт шилжүүлэн ажиллуулах ажлын хэсгийн 2008 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 221 дүгээр тушаалаар нийслэл хот, аймгийн төвөөс сум, сум дундын эмнэлэгт нэр бүхий 7 эмчийг гэрээгээр ажиллуулахаар шийдвэрлэв. Эдгээр эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, гэрээг дүгнэж, гэрээнд заасан хугацаанд Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд ирүүлж байхыг холбогдох аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болголоо.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 223 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбарын хөгжил-3” төслийн Архангай, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн зохицуулагч нарыг томилж, зохицуулагчдын ажлыг 2008 оны 10 дугаар сарын 1-нээс эхлүүлж, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөхцөлөөр хангаж, хяналт тавьж ажиллахыг дээрхи аймгуудын Эрүүл мэндийн газрын дарга, төслийн удирдагч нарт тус тус даалгалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, 13 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны

224 дүгээр тушаалаар эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамж чиглэлийг баталж, нээлттэй хаалганы өдрийг сар бүр тогтмол зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгов.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 227 дугаар тушаалаар тэтгэлэгт сургалт, англи хэлний сургалтад хамрагдах эмч нарын нэрсийг тус тус баталж, сургалтын зардал 27,4 сая төгрөгийг “Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” төслөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэв.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 231 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааг бие даалган хөгжүүлэх замаар даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, тусламж үйлчилгээний чанар хүртээмжтэй уялдуулан хөгжүүлэх зорилготой “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, энэ оны 12 дугаар сарын 1-ний дотор Сайдын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагчид даалгав.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 233 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг баталж, төслийг энэ оны 4 дүгээр улиралд багтаан Сайдын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагчид даалгав.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 234 дүгээр тушаалаар “Эмнэлгийн орны дээд хязгаарыг батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2008 оны 161 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтын Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Дундговь, Ховд аймгийн улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн орны дээд хязгаарт нэмэлт өөрчлөлт орууллаа.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 235 дугаар тушаалаар Эрүүл мэндийн салбарын төсөвт байгууллагуудын төрийн албан хаагчийн 2008 оны нөхөн тоо бүртгэлийг зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг томилж, нөхөн тоо бүртгэлийг удирдамжийн дагуу 2008 оны 10 дугаар сарын 21-нээс 11 дүгээр сарын 5-ны өдрүүдэд зохион байгуулж, тайланг тогтсон хугацаанд нь Төв ажлын хэсэгт хүргүүлэхийг комиссын даргад даалгаж, бүртгэлд хамруулах ажлыг өөрийн байгууллага дээрээ шуурхай зохион байгуулахыг төсөвт байгууллагын Ерөнхий менежер нарт үүрэг болгов.

“Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” хөтөлбөрийн өрхийн эмнэлгийг дэмжих ажлын хүрээнд туссан заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 238 дугаар тушаалаар өрхийн эмч нарыг шинээр бэлтгэх, давтан сургалтад хамруулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн 6 сарын сургалтад нэр бүхий 10 эмчийг хамруулж, сургалтын зардлыг уг хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг төслийн захиралд зөвшөөрөв.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 6 дахь заалт, Засгийн газрын 1996 оны 259 дүгээр тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 230 дугаар тушаалаар Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн баталж, сайдын зөвлөлийн гишүүдэд олгох мөнгөн урамшууллыг Эрүүл мэндийн яамны төсвөөс гаргахыг Төрийн нарийн бичгийн даргад зөвшөөрсөн байна.

10 дугаар сарын 20-ны өдөр яам болон салбарын хэмжээнд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, 400 гаруй хүнд үйлчиллээ.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээнд хийсэн үнэлгээ. Эрүүл мэндийн сайдын 2008 оны 209 дүгээр тушаалаар Дархлаажуулалтын 10 хоногийг “Менингококкт халдвараас сэргийлье” уриан дор энэ оны 10 дугаар сарын 01-нээс эхлэн зохион байгуулж, энэ үеэр менингококкт халдварын өвчлөл өндөр байгаа Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Хэнтий, Булган аймгийн төв, Орхон, Дархан-Уул, Улаанбаатар хотын 2-10 насны хүүхдийг менингококкт халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулав.

Нэн шаардлагатай эмийн хангамжийн мэдээ. 2008 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар эм хангамжийн салбарт зонхилох байр суурь эзэлдэг Монголэмимпекс ХХК, Моносфармтрейд ХХК, Еврофарм ХХК, Нахиа импекс ХХК, Азифарм ХХК-аас ирүүлсэн зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдэлийн мэдээгээр хот, хөдөөд 178 нэрийн нийт 2,7 тэрбум төгрөгийн ҮЗШЭ-ийн үлдэгдэлтэй байна.

Энэ сард ЭМЯ-ны импортын зөвшөөрлийн дагуу нийт 87 эм ханган нийлүүлэх байгууллага гэрээний дагуу импортын лиценцэд заагдсан 520 нэрийн эм, 96 нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 15 нэрийн урвалж бодис оношлуурууд тус тус импортоллоо.

Цочмог халдварт өвчний өвчлөл, нас баралт, эх, хүүхдийн эндэгдлийн мэдээ, үнэлгээ. 2008 оны эхний 9 сард улсын хэмжээнд нийт 47024 эх амаржиж 47164 амьд хүүхэд төрж өнгөрсөн оныхоос төрсөн эх 6875-аар, амьд төрсөн хүүхдийн тоо 6930-аар тус тус нэмэгдсэн байна. Энэ хугацаанд 23 эх эндсэний 10 нь Улаанбаатар хотод, аймгуудаас Баян-Өлгий, Хэнтийд тус бүр 2,

Баянхонгор, Дархан-Уул, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл аймагт тус бүр 1 эх эндсэн байна. Эхийн эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 100000 амьд төрөлтөнд 41,7-оор буурсан байна (100000 амьд төрөлтөнд 48,8 байна).

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 924 тохиолдол бүртгэгдэж өмнөх оныхоос 195-аар, 1000 амьд төрөлтөнд 1,5 пунктээр тус тус нэмэгдсэн, Өвөрхангай 72 (34,8), Дорноговь 29 (31.9), Говь-Алтай 30 (28.7), Архангай 41 (27,2), Хэнтий 32 (29.2), Баянхонгор 39 (25.7), Хөвсгөл 61 (26.2), Говьсүмбэр 7 (32.1), аймагт улсын дундаж /19,6/-аас өндөр байна.

1-5 хүртэлх насны 189 хүүхэд эндсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 8-аар, амьд төрсөн 1000 хүүхдэд 19,6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,5 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

2008 оны эхний 9 сард 31588 халдварт өвчин бүртгэгдсэн нь урьд оны мөн үеийнхээс 1724 тохиолдлоор буурч, 10000 хүн амд 118,8 ногдож байна.

Бүртгэгдсэн халдварт өвчний дотор вирус гепатит, салхинцэцэг, тэмбүү, гонококк халдвар, хүнснээс гаралтай бактерт хордлого зэрэг өвчний тохиолдлын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс нэмэгдсэн байна.

Халдварт өвчний бүтцийн хувьд авч үзвэл зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин 37,1%, гэдэсний халдварт өвчнүүдээс вирус гепатит 22,1%, амьсгалын замын халдварт өвчнөөс сүрьеэ 11,0%, салхин цэцэг 5,6%, гахай хавдар 1.5%-ийг тус тус эзэлж байна. Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнүүдээс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад зэрэг өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Халдварт өвчний улмаас 126 хүн нас барснаас сүрьеэгээр 78, вирус гепатитээр 22, менингококк халдвараар 9, төрөлхийн тэмбүүгээр 3, салхин цэцэг, нярайн цусан үжил, хачигт энцефалит, цусан суулгаар тус бүр 2, хүнсний гаралтай бактерт хордлого, ёлом, хийт үжил, тарваган тахал, ХДХВ-ийн улмаас тус бүр нэг хүн нас барсан байна.

Санхүү, эдийн засгийн салбарт:

“Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын (2008 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, импортын автобензин, дизелийн түлшинд ногдох албан татварыг сэргээх нь зүйтэй гэж үзлээ. Энэхүү тогтоолд 2008 оны аравдугаар сарын 15-ны өдрөөс эхлэн импортоор нийлүүлж буй автобензин, дизелийн түлшний гаалийн албан татварыг “5” хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварыг “10” хувиар, улмаар автобензин, дизелийн түлшний импортод ногдуулах онцгой албан татварыг оруулж байгаа боомтоос нь хамааруулан ялгаатай тогтоож мөрдүүлэхээр тусгасан байна.

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын тухай Засгийн газрын (2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн) хуралдаанаар дахин хэлэлцэж, төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

Олон улсын санхүүгийн зах зээлийн хямралын нөхцөл байдал, түүний үр дагавар, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан танилцуулах ажлын хүрээнд Сангийн яам, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Иргэдийн хадгаламжийг эрсдэлээс хамгаалах тухай зохих саналыг боловсруулж, Ерөнхий сайд, Тэргүүн шадар сайд, Сангийн сайд, холбогдох албаны хүмүүс болон УИХ дахь МАХН-ын бүлгийн гишүүдэд (2008 оны 10 дугаар сарын 13-ны өдөр) танилцууллаа.

Санхүүгийн зах зээлд үүсээд буй нөхцөл байдал, түүний улмаас Монгол Улсад учирч болох сөрөг нөлөөлөл, үр дагавраас урьдчилан сэргийлэх, иргэдийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах, банкинд итгэх итгэлийг сайжруулах, банкны байгууллагын хөрөнгийн зах зээлд оролцох боломж, нөхцөлийг бэхжүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд дэм үзүүлэх чиглэлээр зарим багц арга хэмжээ авахаар төлөвлөсөн байна. Тухайлбал, (1) Банк, санхүүгийн харилцааг зохицуулахад нэн чухал шаардлагатай багц хууль, хуулийн нэмэлт, өөрчлөлтийг яаралтай боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх; (2) Санхүүгийн салбарын дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулан батлуулах, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх; (3) Олон улсын санхүүгийн зах зээлд гарч буй үйл явц манай улсын эдийн засаг, санхүүгийн байдалд хүчтэй, сөргөөр нөлөөлсөн нөхцөлд авах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах; (4) Засгийн газар, санхүүгийн төв байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээний талаархи мэдээллийг олон нийтэд ил тод хүргэх, мэдээллээр хангах арга хэмжээний саналыг боловсруулжээ. Эдгээрийн дотор нэн түрүүнд 13 хуулийг шинээр боловсруулах буюу зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхээр тусгасан байна.

Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын байнгын хороодын болон нэгдсэн хуралдаанаар дөрвөн үе шаттайгаар хэлэлцүүлж, улмаар

эдгээр хуулийг УИХ-ын (2008 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн) нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцэслэн баталсан байна.

Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулиар Монгол Улсын төсвийн 2008 оны орлогыг 1,718.1 тэрбум төгрөгөөр баталсан байсныг төсвийн тодотголоор 1,720.3 тэрбум төгрөгт хүргэж, орлогыг 2.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ. Монгол Улсын төсвийн 2008 оны зарлагыг 1,946.6 тэрбум төгрөгөөр баталсан байсныг төсвийн тодотголоор 1,815.6 тэрбум төгрөгөөр тогтоож зарлагыг 131.0 тэрбум төгрөгөөр бууруулсан байна. Монгол Улсын төсвийн 2008 оны алдагдлыг 228.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 4.2 хувь байсныг төсвийн тодотголоор алдагдлыг 95.3 тэрбум төгрөг болгож, түүний ДНБ-д эзлэх хувийн жинг 1.6 хувь байхаар тогтоож, алдагдлын хэмжээг даруй 2.5 нэгжээр багасгахаар тооцсон байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг 2008 оны 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн гаргаж, дүнг Засгийн газрын (2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн) хуралдаанд танилцуулж, улмаар Засгийн газрын хуралдаанаас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг УИХ-д танилцуулахаар тогтсон байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн явц 2008 оны 3 дугаар улирлын байдлаар 71.5 хувьтай гарсан байна.

Хөрөнгө оруулалтын 2008 оны төлөвлөгөөний эхний есөн сарын гүйцэтгэлийн тухай Засгийн газрын (2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн) хуралдааны үеэр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Засгийн газрын гишүүдэд танилцуулсан байна. Үүнтэй холбогдуулан улсын хөрөнгө оруулалтаар 2008 онд 408.0 тэрбум төгрөгийн барилга байгууламж, их засварын ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2008 оны эхний 9 сарын байдлаар барилга угсралтын ажил 234.2 тэрбум төгрөгийн буюу 30.7-63.7 хувь, санхүүжилт 177.1 тэрбум төгрөг буюу 42.4-48.4 хувийн гүйцэтгэлтэй гарч байна. Барилгын тухай хуульд “Зураг төсөвгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно” гэж заасныг хөрөнгө оруулалт төлөвлөхдөө анхаарч ажиллах, улмаар зам, барилгын ажилд үндэсний мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, тендер шалгаруулах үзүүлэлтийг оновчтой тогтоож, мэдээллийн ил тод байдлыг хангах зэргээр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт санхүү, төсөв, эдийн засгийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээг тодотгон боловсруулж, төслийг Ажлын хэсгийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөхөд (2008 оны 10 дугаар сарын 4-ны өдөр) хүргүүлжээ. УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны хамтарсан хурлаар Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн анхны хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлтэй хэрхэн уялдсан тухай судалгааны дүгнэлт, танилцуулга бэлтгэж, дүнг Засгийн газрын ээлжит хуралдаанд танилцуулж, улмаар УИХ-ын Тамгын газарт хүргүүлжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны III улирлын гүйцэтгэлийн тухай Засгийн газрын (2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн) хуралдаанд танилцууллаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны эхний есөн сарын буюу эхний гурван улирлын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж, олон нийтэд мэдээлэв. Үүнд:

(1) Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2008 оны эхний есөн сарын гүйцэтгэлээр 1,619.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 30.3 тэрбум төгрөгөөр буюу 1.8 хувиар тасарч, харин 2007 оны мөн үеийнхээс 31.5 хувиар буюу 388.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө тасарсан хэдий ч зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 36.4 хувиар буюу 89.5 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 20.4 хувиар буюу 26.0 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг эх үүсвэрээр нь задалж үзвэл татварын орлогоор 87.4 хувийг, татварын бус орлогоор 11.9 хувийг, хөрөнгийн ба тусламжийн орлогоор 0.7 хувийг бүрдүүлсэн байна.

(2) Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2008 оны эхний есөн сарын төлөвлөгөөгөөр 2,052.6 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 1,522.6 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр 1,622.2 тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 1,249.3 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 79.0 хувийг (улсын төсвийн зарлагын 82.1 хувийг) санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн 2007 оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 748.8 тэрбум төгрөгөөр буюу 85.7 хувиар (улсын төсвийн зарлага 2007 оны мөн үеийнхээс 426.7 тэрбум төгрөгөөр буюу 51.9 хувиар) өссөн байна. Монгол Улсын төсвөөс 2008 оны эхний 3 улирлын байдлаар цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн тавьж олгосны зэрэгцээ нийгмийн халамжийн санд 43.4 тэрбум төгрөг, хүн амын хөгжлийг дэмжих сангуудад 51.1 тэрбум төгрөг, харин Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 66.0 тэрбум

төгрөг (бүгд 160.4 тэрбум төгрөг)-ийн санхүүжилт олгосон байна. Мөн улсын төсвөөс нийгмийн даатгалын сангийн алдагдлыг нөхөхөд зориулан 118.8 тэрбум төгрөгийн татаас олгосон байна.

(3) Орон нутаг 2008 оны эхний есдүгээр сарын гүйцэтгэлээр төсвийн орлогын төлөвлөгөөг 5.4 хувиар буюу 7.6 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлж, төсвийн зарлагын 98.5 хувийг буюу 2.2 тэрбум төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас 40.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 37.7 тэрбум төгрөгийг оруулж, харин Дорноговь, Өмнөговь аймаг болон Улаанбаатар хот улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна.

(4) Монгол Улсыг хөгжүүлэх санд 2008 оны эхний есөн сард зарим бараа бүтээгдэхүүний албан татвараар 335.1 тэрбум төгрөг төвлөрүүлж, сангийн оны эхний үлдэгдлээс 0-18 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид 71.5 тэрбум төгрөг; Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 66.0 тэрбум төгрөг (нийт 137.4 тэрбум төгрөг)-ийг зарцуулсан байна.

(5) Монгол Улсын нэгдсэн төсвийн (өссөн дүнгээр) 2008 оны эхний есөн сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 382.3 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 3.1 тэрбум төгрөгийн алдагдалтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 29.5 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 164.8 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарсан байна. Улсын төсвийн алдагдал сар тутам өсөн нэмэгдэж байгаагаас улсын төсвийн орлого төлөвлөгдсөн хэмжээнд бүрдэж чадаагүйтэй шууд холбоотой байна.

Улсын төсөвт байгууллагын 2008 оны эхний есөн сарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 2008 оны эхний есөн сарын өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж, ОУВС-д хүргүүлээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны эхний есөн сарын гүйцэтгэлээр (2008 оны аравдугаар сарын 1-ний үлдэгдэл) төсөвт байгууллагын төсвийн нийт авлага 6.1 тэрбум төгрөгт, төсвийн нийт өглөг 8.7 тэрбум төгрөгт хүрч, төсвийн авлага, өглөг 2008 оны эхнээс нэмэгдсэн байна.

Нийт өглөгийн 19.4 хувийг цалин, хөдөлмөрийн хөлс, 17.6 хувийг түлш, халаалтын зардал, 16.3 хувийг эмийн зардал, 8.4 хувийг байрны түрээсийн зардал, 7.8 хувийг хоолны зардал, 30.5 хувийг бусад зардал эзэлж байна. Мөн улсын төсвийн байгууллагын цалин, нийгмийн даатгалын шимтгэл 33.2 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардал нийтдээ 57.8 тэрбум төгрөг (үүнээс: түлш, халаалтын хэмнэлт 5.2 тэрбум төгрөг, хоолны зардлын хэмнэлт 5.6 тэрбум төгрөг, эмийн зардлын хэмнэлт 1.9 тэрбум төгрөг)-өөр хэмнэгдсэн харагдаж байна. Иймд улсын төсвийн зардлын зүйл хооронд зарим зохицуулалтын шийдвэр гаргавал улсын төсвийн өр, төлбөрийг барагдуулах боломж байна.

Монгол Улсын нэгдсэн төсөв нь 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн улсын төсөв, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн төсөв гэсэн дөрвөн төсвийн гүйцэтгэлийг нэгтгэн гаргадаг боллоо. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны есдүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг (2008 оны 10 дугаар сарын 7-ны өдөр) нэгтгэн гаргаж, дүнг яамны удирдлага болон Үндэсний статистикийн газар, Монголбанк, ОУВС зэрэг нийт 13 газарт хүргүүлж мэдээлсэн байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2007 оны дөрөвдүгээр сарын гүйцэтгэл, тайлангийн үндсэн үзүүлэлтийг Сангийн яамны вэб хуудсанд (2008 оны 10 дугаар сарын 9-ний өдөр) байрлуулан олон нийтэд нээлттэй, ил тод танилцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Болгар Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсаас Болгар Улсад төлөх 10.6 сая шилжих рублийн өрийг зохицуулах хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Энэхүү өрийн 75 хувийг бүрэн хөнгөлөлж, үлдэх 2.1 сая долларын өрийг Болгар Улсад хөдөө аж ахуйн чиглэлээр оюутан сургах, хөдөө аж ахуйн салбарын шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэх хэлэлцээрийг салбарын яамд байгуулахаар тохиролцсон болно.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хуульзүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн болон “Уул уурхайн техник туслалцааны төсөл”-ийн Санхүүжилтийн гэрээ, түүнчлэн “Хөдөөгийн боловсролыг дэмжих төсөл”-д олгох нэмэлт 620.0 мянган ам.долларын Зээлжих тусгай эрхийн буцалтгүй тусламжийн санхүүжилтийн гэрээнд (2008 оны 10 дугаар сарын 7-ны өдөр) хоёр тал тус тус гарын үсэг зурсан байна.

Сангийн сайдын (2008 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 341 дүгээр) тушаалаар байгуулсан ажлын хэсэг Азийн хөгжлийн банкны 10 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Боловсролын салбарын шинэчлэлийн төсөл”-ийн хэлэлцээг Азийн хөгжлийн банктэй амжилттай явуулсан байна. Хэлэлцээний явцад санхүүжилтийн нийт дүнд зөвлөх үйлчилгээний зардал 19.7 хувийг эзэлж байсныг 9 хувь болтол бууруулж, Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэх зардлын хувь хэмжээ 90.9 хувь байсныг зуун хувь болгохоор тохиролцсон байна.

Азийн хөгжлийн банкны 14.7 сая ам. долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн буцалтгүй тусламжийн гэрээнд Сангийн сайд, Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгч (Адриан Руденберг) нар гарын үсэг зурж баталгаажууллаа. Түүнчлэн Азийн хөгжлийн банкны Японы ядуурлыг бууруулах сангаас санхүүжүүлэх “Ядуу малчин

өрхүүдэд зориулан худаг шинээр гаргах, сэргээн засварлах төсөл” (2.0 сая ам.доллар) болон “Олон нийтийн оролцоотойгоор байгалийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, ядуурлыг бууруулах төсөл” (2.0 сая ам.доллар)-ийн гэрээнд Сангийн сайд, Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд нар (*2008 оны 10 дугаар сарын 16-ны өдөр*) гарын үсэг зурж баталгаажуулав.

Азийн хөгжлийн банкны 2007 оны төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны үнэлгээний тухай тайланд Сангийн яамны зүгээс зөвлөх үйлчилгээний чанарыг сайжруулах, төслийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр тавьсан саналыг тусгаж, Харилцан ойлголцлын санамж бичигт Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Азийн хөгжлийн банкны төсөл, хөтөлбөрийн ахлах мэргэжилтэн (Шейн Розентал) нар гарын үсэг зурлаа.

Японы Засгийн газрын ерөнхий буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх “Бага, дунд боловсролын сургуулийн барилга барих, өргөтгөлийн 4 дэх шатны төсөл”-ийг эхлүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн судалгааны тайлантай танилцаж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийслэлийн Боловсролын газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага болон зөвлөх багтай холбогдох баримт бичгийн төслийг хэлэлцэн тохиролцсоны дагуу Протоколд (*2008 оны 10 дугаар сарын 17-ны өдөр*) гарын үсэг зурсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын урилгаар Люксембургийн Их Гүнт Улсын Ерөнхий сайд (ноён Жан-Клод Юнкер) Монгол Улсад (*2008 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд*) албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын явцад Люксембургийн Их Гүнт Улсаас Монгол Улсад НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлэх “Хил дамнасан ДОХ-оос сэргийлэх нь” төсөлд 358,985 евро, “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг хөгжүүлэх” төсөлд 1,400,968 евро, “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл”-д 2.0 сая евро олгохоор боллоо. Буцалтгүй тусламж олгох тухай Харилцан ойлголцлын санамж бичигт Монгол Улсын Сангийн сайд, Люксембургийн Их Гүнт Улсын Хөгжлийн хамтын ажиллагааны сайд нар гарын үсэг зурсан байна.

Монгол-Японы Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлийн Хоёрдугаар зөвлөлдөх уулзалтыг (*2008 оны 10 дугаар сарын 10-ны өдөр*) зохион байгуулж, түүнд хоёр талын Засгийн газрын 90, хувийн хэвшлийн 70 орчим төлөөлөгч оролцсон байна. Энэхүү уулзалтын үеэр анхдугаар зөвлөлдөх уулзалтаас хойш хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээлж, хувийн хэвшлийн төлөөлөгчид өөрийн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны зарим төслийн талаар танилцуулж, хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд гарч буй нааштай алхам зэргийг хөндөн ярилцсан байна.

Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх зөвлөлдөх зөвлөлийн ээлжит хуралдааныг Төрийн ордонд (*2008 оны 10 дугаар сарын 23-ны өдөр*) зохион байгууллаа. Энэхүү хуралдаанаар төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын хамтарсан түншлэлийн зарчмаар Замын-Үүдэд ложистикийн төв байгуулах, Цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх тухай хэлэлцэж, эдгээр төслийг бодит ажил болгон ажиллах тухай зөвлөмжийг гаргасан байна.

Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банктай хамтран “Эдийн засгийн бодлогын чуулга уулзалт”-ыг Улаанбаатар хотноо (*2008 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд*) амжилттай зохион байгууллаа. Уул уурхайн салбарын хөгжил эрчимжихийн хэрээр эдийн засаг тогтворгүйжиж буй өнөөгийн нөхцөлд манай эдийн засгийн бодлогыг шүүн хэлэлцсэн нь цаг үеэ олсон төдийгүй эдийн засгийн асуудал иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж буй тухай мэдэхийг хүссэн олон нийтийг өргөнөөр оролцуулсан, тэдэнд үнэтэй мэдээлэл, мэдлэг өгсөн анхны чуулга уулзалт боллоо гэж хоёр тал дүгнэсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт:

“Ашигт малтмал олборлох, боловсруулахад үүсэх хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээ, хохирол тооцох аргачлал”-ыг улсын бүртгэлд бүргүүлэв.

“Ойгоос хууль бусаар мод бэлтгэх, худалдаалах, түүнтэй холбогдон үүсч болзошгүй хууль бус үйлдэл, авилгалыг таслан зогсоох үйл ажиллагааг зохицуулах зөвлөл байгуулж, уг зөвлөлөөс Ойн хэрэг эрхлэх газрын дэргэд Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх албыг байгуулан ажиллаж байна.

“Ойн хэрэг эрхлэх газар байгуулах тухай” Засгийн газрын 2008 оны 212 тоот тогтоол гарсантай холбогдуулан Байгаль орчны сайдын 2008 оны 226 тоот тушаалаар Агентлагийн дүрэм болон бүтэц, орон тоог батлав.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг 85 төсөлд гаргаж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний 54 тайланг хэлэлцэн батлав.

Химийн бодисын тусгай зөвшөөрлийг 23 аж ахуйн нэгжид, Ургамлын тусгай зөвшөөрлийг 5 аж ахуйн нэгжид олголоо.

Уул уурхайн 4 аж ахуйн нэгжийн 2008 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хянан батлуулж 22.03 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний барьцаа болгон тусгай дансанд төвлөрүүлээд байна.

Химийн бодисоор бохирдсон ул хөрс шламыг хоргүйжүүлэх саармагжуулах ажлыг 6 аймгийн 15 сумын 115 цэгт хуримтлагдсан 47342 м² буюу 71015 тонн хөрсөнд хийж, химийн бодисоор бохирдсон 27 905 м² талбайн хөрийг хуулж саармагжуулан, 24750 тонн хаягдлыг булшлаад байна.

Архангайд 65.0 мянган га, нийслэлийн ногоон бүсэд 40.0 мянган га, Хөвсгөлд 100.0 мянган га, Булган аймагт 76.0 мянган га, Сэлэнгэ аймагт 40.0 мянган га нийтдээ 321.0 мянган га ойтой талбайд ойн хөнөөлт шавьж, өвчний намрын тандалт судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Засгийн газрын 2007 оны 345 дугаар тогтоол, Байгаль орчны сайдын 2008 оны 02 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаадын анчдад угалз 60 толгой, тэх 200 толгой, харсүүлтий зээр 20 толгой агнуулахаас урьдчилсан байдлаар угалз 56 толгой, тэх 184 толгой, харсүүлтий зээр 6 толгой агнуулж, улс, орон нутгийн төсөвт 771.8 сая төгрөгийн төлбөр, хураамжийн орлого төвлөрүүлээд байна.

Арабын орнуудтай хийсэн хамтын ажиллагааны гэрээний дагуу 300 толгой идлэг шонхор шувуу гаргахаас, 251 идлэг шонхор шувуу бариулж, гаргах ажлыг зохион байгуулж, урьдчилсан байдлаар улс, орон нутгийн төсөвт 2 567 600 ам.долларын төлбөр, хураамжийн орлого төвлөрүүлээд байна.

Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Улаагчны хар нуурыг түшиглэн байгуулсан Байгаль нуурын оморь загасны үрийн сан, үржүүлгийн төвийг цаашид инкубатор-технологийн хэлбэрээр ажиллуулахаар шийдвэрлээд байна.

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн хууль бус худалдааг таслан зогсоох, иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзэл бодолтой болгох зорилготой “Татгалзая” үзэсгэлэнг “Амьтны эрх ашиг хамгаалах сан” ТББ-тай хамтран зохион байгуулж, үзэсгэлэнгийн байрны түрээсийн төлбөр болох 1 710 000 төгрөгийг Байгаль хамгаалах сангаас гаргаж санхүүжүүлэв.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт гарсан цагаан зээрийн цусан халдварт өвчний тархалтын хүрээг тогтоож, өвчний голомтыг устгах арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, байнгын хяналтанд авлаа.

Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас явуулсан ажиглалт судалгаагаар энэ жил хулангийн унага элбэг, 20-100 орчим тоо толгойгоор сүрэлгэсэн олон сүрэг амьдарч байгаа нь хулан өсөх хандлагатай байгааг харуулж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгуудад малын тоо толгой өсөн нэмэгдэж тухайн газрынхаа даацад ихдэх болсныг харгалзан гаднаас мал оруулан өвөлжүүлэх асуудлыг аль болох хязгаарлах бодлого баримталж байгаа боловч цаг агаар хүндэрсэн нөхцөлд Тусгай хамгаалалттай 16 газрын хязгаарлалтын бүсэд 2019-2033 өрх айлын 31110-32310 бод, 521965 бог мал өвөлжүүлэх бололцоотой гэсэн судалгааг гаргаж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэв.

Усны нөөц ашиглуулах мэргэжлийн дүгнэлтийг “АУМ” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг дэвсгэрт орших Хөшөөтийн алтны шороон орд, “Ханилчигбуг” ХХК-ийн Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт орших Бөхөгийн голын элс, хайрганы уурхай, “Трейжа Маунтайн Интернейшнл” ХХК-ийн Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Зүүн хоолойн барилтын ордын технологийн хэрэгцээнд, “Улаанбаатар хотын ТЭЦ-3 ХК-ийн технологийн хэрэгцээнд тус тус гаргав.

Нээлттэй хаалганы өдрийг “Ой усаа хамгаалахад иргэн бүр идэвхтэй оролцоцгооё” уриан дор зохион байгууллаа. Өдөрлөгт байгаль орчны чиглэлийн ТББ-ын төлөөлөгчид, багш, оюутан сурагчид, судлаачид, ард иргэдийг төлөөлсөн 300 орчим хүн оролцож мэдээлэл авлаа. Иргэдийн санал хүсэлтийг амаар болон бичгээр хүлээн авч, иргэдийн асуултад яамны холбогдох мэргэжилтнүүд газар дээр нь шуурхай хариу өгч ажиллалаа.

Цаг уурын мэдээлэл, орчны шинжилгээний ажил. Булган аймгийн Могод суманд цаг уурын станцын шинэ барилгыг ашиглалтад хүлээж авч, Баянхонгор аймгийн агаарын чанарын харуулыг Байгаль орчны шинжилгээний лаборатори болгон зохион байгуулж, Баруунхараад цаг уурын автомат станц, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын цаг уурын станцад агаар дахь шороо, тоосны агууламж, цаг уурын үзүүлэлтүүдийн градиентийн хэмжилт хийх төхөөрөмжүүдийг иж бүрнээр суурилуулж дуусгав.

Цаг агаарын урьдчилсан мэдээ. Цаг агаарын урьдчилсан мэдээний ерөнхий таарц төлөвлөгөөт даалгавраас 5.9-9.7 хувиар дээгүүр, өнгөрсөн оны мөн үеэс 5 хоногийн мэдээний таарц 0.7 хувиар дээгүүр, сэрэмжлүүлэг мэдээний чанар өнгөрсөн оны хэмжээнд байна.

Хоногийн урьдчилсан мэдээг цочир хүйтрэлээр 3 удаа буюу 9 дүгээр сарын 22, 24, 30-нд сэрэмжлүүлэг мэдээ зохиож урьдчилсан мэдээллээ.

Орон нутгийн цаг агаарын урьдчилан мэдээлэх албаны нарийвчилсан урьдчилсан мэдээний таарц 97.2 хувь, өмнөх оны мөн үеэс 0.3-иар ахиу, хоногийн урьдчилсан мэдээний таарц 95.0 хувь байв. Энэ сард Увс, Говь-алтай аймгуудын нарийвчилсан мэдээний таарц 100.0 хувь байна.

Урьдчилан мэдээлэх албад нийт 49 удаа цочир хүйтрэлээр хоногийн сэрэмжлүүлэг мэдээ зарласан бөгөөд ерөнхий таарц 71.2 хувь байв.

Олон улсын шугамд ниссэн 255, орон нутгийн 336, онцгой, тусгай үүргийн 19 нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилсэн. Чингис хаан олон улсын нисэх буудлын 24 цагийн урьдчилсан мэдээ 90 удаа, 9 цагийн урьдчилсан мэдээ 241 удаа зохиосноос мэдээний таарц 94.7% байна.

Агаарын шинжилгээ. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах харуулууд 168 сорьц авч шинжилгээ хийж, хөтөлбөрийн биелэлт 96.7-100 хувьтай байна.

Шинжилгээний дүнгээс үзэхэд хүхэрлэг хийн дундаж агууламж 0.004 мг/м^3 , хамгийн их нь 0.012 мг/м^3 хүрч, нийт 54 удаагийн ажиглалтаар Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна. Азотын давхар ислийн дундаж агууламж 0.024 мг/м^3 , хамгийн их нь 0.037 мг/м^3 хүрч, нийт 54 удаагийн ажиглалтаар хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна.

Усны шинжилгээ. Шинжилгээгээр Туул голын ус хотоос дээш хэсэгт Уубулан, Зайсангийн орчим бохирдолгүй цэвэр байсан ба Налайх, Баянзүрхийн орчим голын усанд нитритийн азотын агууламж Усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас бага зэрэг давсан байна.

Хотоос доош буюу хотын төв цэвэрлэх байгууламжийн хаягдал нийлснээс доош Сонгиноос Алтанбулаг сум хүртэлх хэсэгт голын усан дахь аммонийн азотын агууламж хүлцэх агууламжаас 8-9.3 дахин, нитритийн азотын агууламж хүлцэх агууламжаас 1.1- 2.3 дахин, эрдэс фосфорын агууламж хүлцэх агууламжаас 3.1- 3.6 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч агууламж хүлцэх агууламжаас 1.2- 2.4 дахин давсан бохирдол илэрчээ.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцод хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд Төв цэвэрлэх байгууламж 86%, Нисэхийн цэвэрлэх байгууламж 68%, Налайхын цэвэрлэх байгууламж 83%, Био орон сууцны цэвэрлэх байгууламж 63%-ийн цэвэршилттэй байсан байна.

Аялал жуулчлал. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон төрийн бус байгууллагууд хамтран 2008 оны 10 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Зүүн хойд Азийн аялал жуулчлалын 5-р чуулганыг Улаанбаатар хотод зохион байгуулав. Чуулганд ОХУ, БНХАУ, БНСУ, БНАСАУ болон Япон улсын төрийн болон төрийн бус байгууллага, аялал жуулчлалын компани, эрдэм шинжилгээний байгууллагуудын 220 төлөөлөгч оролцлоо. Энэхүү чуулганы үр дүнд Зүүн хойд Азийн бүс нутаг аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хил дамнасан аялал жуулчлал; “Дорнын тойрог”, “Их цайны зам” маршрутыг хөгжүүлэх, бүсийн аялал жуулчлалын нарийн бичгийн газар байгуулах зэрэг асуудлуудыг тусгасан хамтарсан мэдэгдэлд 5 орны төлөөлөгчид гарын үсэг зурав.

АНУ-ын Охайо мужийн Мидлтаун хотноо “Монголын өдрүүд” арга хэмжээг АНУ-ын Мидфест Интернэшнл төрийн бус байгууллага, Мидлтаун хотын захиргаа, Монгол Улсаас тус улсад суугаа Элчин сайдын яам, Гадаад харилцааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам хамтран зохион байгуулав. 2008 оны эхний 9 сарын байдлаар Монгол Улсад 359639 гадаадын жуулчин ирсэн нь 2007 оны мөн үеийнхээс 2.2 хувь буюу 7786 жуулчнаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зам тээвэр, барилга, хот байгуулалтын салбарт:

Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын төлөөлөгчийн газарт олгосон газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай УИХ-ын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, УИХ-аар тус тус хэлэлцүүлэв.

“Эко-Яармаг хороолол” төслийн талаар санал боловсруулж Засгийн газрын 2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлжээ. Уг хуралдаанаас төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа газрын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эхний ээлжинд шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж тэмдэглэсний дагуу газрын асуудлыг УИХ-д танилцуулахаар дахин санал боловсруулав.

“40000 орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний тухай танилцуулга, холбогдох мэдээ, судалгааг гаргаж ЗГХЭГ-т хүргүүлэв.

ХБНГУ-ын KfW банкны зээл, тусламжаар хэрэгжих “Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-ийн техник, эдийн засгийн үндэслэл, барилгын хяналт хийх зөвлөлтэй 10 дугаар сарын 17-ны өдөр гэрээ байгууллаа. Судалгааны ажлыг 11 дүгээр сарын 5-наас эхлүүлэхээр төлөвлөж байна.

Азийн хөгжлийн банк /АХБ/-ны буцалтгүй тусламжаар хэрэгжих “Баруун бүсийн авто замыг хөгжүүлэх төсөл, 1-р үе шат”-ийн барилгын хяналт хийх олон улсын зөвлөх компанийг сонгон шалгаруулах эхний үе шатны ажлыг гүйцэтгэж богино жагсаалтад үлдсэн компанийг АХБ-нд хүргүүлэхээр тайланг боловсруулж дуусгалаа. Мөн дараагийн шатны сонгон шалгаруулалтын тендерийн баримт бичгийг боловсруулан Сангийн яам болон АХБ-нд хүргүүлэв.

Улсын чанартай авто зам, даваан дээр өвлийн улиралд гарч болох аливаа саатал буюу цас, мөсийг арилгах, бүхий л төрлийн тээврийн хэрэгслүүдийг саадгүй зорчуулах зорилго бүхий авто замын засвар, арчлалтын “Шуурхай ажлын хэсгүүд”-ийн байршил, ажиллах хүн хүч, машин механизмын нэг сард зарцуулах зардлыг тооцоолж, нэгж зардлын бүтцийг шинэчлэн боловсруулж, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2008 оны 10-р сарын 29-ны өдрийн 22 дугаар тушаалаар батлуулав.

Авто замын барилгын ажилд шаардагдах шатах тослох болон барьцалдуулагч материалын үнэ өссөнтэй холбогдуулан тэдгээрийн үнийн зөрүүг тооцож холбогдох яам, газруудад шийдвэрлүүлэхээр хүргүүлэв.

Засгийн газрын 2002 оны 9-р сарын 4-ний өдрийн 177 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Олон улсын болон Улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчин явж буй тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс авто зам ашигласны төлбөр хураамж авах” ажлыг одоогийн ажиллаж байгаа 15 цэгт ажиллуулж, эхний 10 сарын байдлаар Улсын авто замын санд 683,0 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 120%-иар давуулан биелүүлж ажиллав.

Улсын чанартай авто зам, замын байгууламжуудын засвар, арчлалтын ажлуудын гүйцэтгэл оны эхний өссөн дүнгээр 6 тэрбум 788,990 сая төгрөг буюу 75,5%-тай байна. Дээрх ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэхээр Санхүү, хөрөнгө оруулалтын газарт гүйцэтгэлүүдийг баталгаажуулан хүргүүлэв.

Улсын чанартай авто зам, замын байгууламжуудыг тэмдэгжүүлэх ажлын хүрээнд Улсын чанартай А-04 Улаанбаатар-Дархан, А-0301 Улаанбаатар-Арвайхээр, А-0601 Элсэнтасархай-Хархорин, А-0101 Улаанбаатар-Чойр, А0501 Улаанбаатар-Өндөрхаан болон бусад чиглэлийн хатуу болон хайрган хучилттай авто замуудад тэмдэг, тэмдэглэгээний ажлуудыг тухайн чиглэлийн авто замыг хариуцагч байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэв.

Улсын ургац, тээвэрлэлтийн авто замыг ургац тээвэрлэлтэнд бэлэн байлгах зорилгоор Сэлэнгэ, Орхон, Булган аймгуудын ургацын зам, гүүрүүдийг засварлуулав.

Улсын чанартай авто зам, замын байгууламжуудад дулааны улиралд орсон хүчтэй аадар, үерийн улмаас үүссэн гэнэтийн эвдрэлүүдийг засварлах гэрээг орон нутгийн зам засвар арчлалтын байгууллагуудтай хийж, тээврийн хөдөлгөөн саадгүй зорчуулах нөхцөлийг хангаж, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллав.

Авто замын засвар, арчлалтын ажлын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх зорилгоор “Орхон АЗЗА” ХК-ий шинэ контор, гаражын барилгыг ашиглалтанд оруулав.

Авто замын засвар, арчлалтын ажлын үйлдвэрлэлийн бааз, парк шинэчлэлтийн ажлын хүрээнд “Дархан АЗЗА” ХК, “Өвөрхангай АЗЗА” ХК-д цас цэвэрлэгч ротор бүхий, замын засварын машиныг хүлээлгэж өгөв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зорилгоор Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт хараа, сонголын бэрхшээлтэй иргэдийн орон сууцнаас дээрх хүмүүсийн ажилладаг үйлдвэрийн ажлын байр хүртэлх зам тавьж ашиглалтанд оруулав.

Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжигдэн Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт баригдсан 9.3 у/м төмөр бетон гүүрийг улсын ашиглалтанд оруулав.

Улсын хэмжээгээр 185 барилга байгууламж ашиглалтанд орсноос, 3845 айлын, 294874.3 м² сууцны талбай бүхий 90 орон сууцны барилга ашиглалтанд орсон байна.

“Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”, “Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлж байгаа саналыг тусгаж дахин боловсруулалт хийв.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулав.

Монгол орны Баруун бүсийн 5 аймгийн инженер-геологийн нөхцөл, хөрс чулуулгийн геотехникийн нөхцөлийг тогтоож, төслийг ажлын хэсэгт хүргүүлэв.

Азийн хөгжлийн банк, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны хооронд төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, авлигыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурахаар харилцан тохиролцож, Азийн хөгжлийн банкинд саналаа хүргүүлэв.

10 дугаар сарын 20-ний өдрийг “Нээлттэй хаалганы өдөр” болгон зохион байгуулж, яам, түүний харъяа байгууллагууд үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилж, хууль эрх зүйн зөвлөгөө, тайлбар өгөх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч цаашдын бодлого үйл ажиллагаандаа тусгах чиглэлээр ажиллалаа.

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг заалт бүрээр гаргаж Сангийн яаманд хүргүүлэв.

Иргэд, олон нийтийн санал бодлыг сонсох, тэдгээрийг шийдвэр, үйл ажиллагаандаа тусгах зорилгоор Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2008 оны 10 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгуулснаас салбарын дүнгээр нийт 1426 санал, хүсэлт ирсний 1118-ийг нь мөн өдрөө шуурхай шийдвэрлэж ажиллав.

“Эрс шинэчлэл” хөдөлгөөнөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу хөдөлгөөний төлөөлөлтэй яамны удирдлага уулзаж, уулзалтын тайланг ЗГХЭГ-т хүргүүлэв.

Тайлант хугацаанд эрдэс баялаг, эрчим хүчний бодлогын төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн танилцуулгыг боловсруулж, УИХ-аас томилогдсон ажлын хэсэгт хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын талбайг нөөцөд авах ба гүйцэтгэж дууссан талбайг нөөцөөс чөлөөлөх тухай танилцуулгыг Засгийн газрын тогтоолын төслийн хамт боловсруулж хүргүүлэв.

Монголын газрын ховор элементийн тухай мэдээллийг ҮАБЗ-д хүргүүлэв.

“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамдын саналыг авч байна.

2008 оны болон өнгөрсөн оны улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байгаагаас Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн дулааны шугамыг ашиглалтад хүлээж авах Улсын комисс ажиллав. Тус шинэчлэлийн ажлын дүнд аймгуудын дулааны шугам сүлжээний найдвартай ажиллагаа дээшилж, тасалдал, доголдол багасч байгаа юм. Түүнчлэн Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Манхан, Зэрэг, Дарви, Чандмань сумдын төвийг Баруун бүсийн эрчим хүчний системд холбох өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажилд Улсын комисс ажиллаж, холбогдох үүрэг даалгаврыг өгч хэрэгжилтийг хангуулж байна. Мөн тус аймгийн Толбо сумын төвийг Баруун бүсийн эрчим хүчний системд холбох 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажилд ажлын комисс ажиллаж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

Улсын төсвийн болон Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй сэргээгдэх эрчим хүчний объектуудын явц байдал, тэдгээрт суурилуулсан тоног төхөөрөмжүүд гэрээнд заагдсан техникийн тодорхойлолтод нийцсэн эсэх, улмаар гэрээний үүргийн хэрэгжилтийн талаарх мэдээллүүдийг нэгтгэн судлахаар Баянхонгор аймгийн Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдад ажиллаж, холбогдох заавар, зөвлөмжийг өгөв.

Монгол Улсыг хөгжүүлэх болон улсын төсвийн хөрөнгөөр 2008 онд ашиглалтанд орох ёстой хэдий ч хугацаандаа хийгдэж чадахгүй байгаа цахилгаан дамжуулах шугам, дэд станцуудын барилга байгууламжийн объектуудын судалгааг гаргаж хугацааг сунгав.

Орон нутгийн дулаан хангамжийг сайжруулах төслийн хүрээнд Булган аймгийн Могод, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Дорноговь аймгийн Айраг, Төв аймгийн Аргалант сумдын дулаан хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 95-100 хувьтай байгаагаас Булган аймгийн Могод суманд гүйцэтгэсэн ажлыг Улсын комисс хүлээж авав. Тус төсөл хэрэгжсэнээр дээрх сумдын халаалт сайжирч найдвартай болохын зэрэгцээ түлшний зарцуулалт багасч, агаарын бохирдлыг бууруулах юм.

Аймгийн төвүүдийн дулаан хангамжийн талаар техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нээж, үнэлгээний ажлыг гүйцэтгэж байна.

Түлш, эрчим хүчний салбарын байгууллагуудын 2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, хяналт тавих чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаагаас салбарын хэмжээнд өвлийн бэлтгэл хангах ажил 84 хувийн биелэлттэй байна.

Салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн ажлаас дурдвал:

ХБНГУ-ын KFW банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрчим хүчний хөтөлбөр-1” төслийн хүрээнд хийгдсэн Дарханы дулааны цахилгаан станцын хаалттай хуваарилах байгууламжийн шинэчлэлтийн ажил дуусч Улсын комисс хүлээж авав.

Түүнчлэн тус улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Дарханы дулааны цахилгаан станцад шинэ турбогенератор суурилуулах” төслийн зөвлөхийн тендерийг зарлаад байна.

2008 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсны дагуу эхний 10 сарын байдлаар түлш, эрчим хүчний салбарт 29946.2 сая төгрөг, эрдэс баялагийн салбарт улсын

төсвийн хөрөнгө оруулалтаар 2.3 тэрбум төгрөгийн урьдчилгаа болон үе шатны ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлж ажиллав.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар түлш, эрчим хүчний салбарт 2008 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөгөөнд тусгагдсан сумдын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэхээр Түлш, эрчим хүчний сайдын 2008 оны 116, 125, 134, 138 дугаар тушаалын дагуу нийт 123 сумдын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын гэрээ болон урьдчилгаа төлбөрийн баталгааг хянан үзэж Сангийн яаманд хүргүүлэн нийт 3256.5 сая төгрөгийг санхүүжүүлээд байна.

Алдагдалтай ажилладаг эрчим хүчний үйлдвэрүүдэд 2008 оны төсвийн тодотголоор нэмж батлагдсан санхүүжилтийг олгох сарын хуваарийг боловсруулан Сангийн сайдаар батлуулж, Налайхын дулааны станцад 73,2 сая төгрөг, Даланзадгадын дулааны цахилгаан станцад 138,0 сая төгрөг, Баруун бүсийн эрчим хүчний систем компанид 600,0 сая төгрөг, Багануурын дулааны станцад 100,0 сая төгрөг буюу 2008 оны 9, 10 дугаар саруудад олгох бүгд 911,0 сая төгрөгийн хуваарилсан санхүүжилтийг тус тус олгуулав.

Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд 2008 оны 10 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Кувейт Улсад албан ёсны айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тус улсад хийсэн айлчлалын мөрөөр Монгол Улсад нефть импортлох боломжийн талаар хийсэн уулзалтын үеэр яригдсаны дагуу нефть болон нефтийн бүтээгдэхүүн импортлох санамж бичгийн төсөлд харилцан санал солилцов.

Түүнчлэн 2008 оны 10 дугаар сарын 28-наас 11 дүгээр сарын 1-ний өдрүүдэд Казакстан улсад албан ёсны айлчлал хийж, Монгол Улсад түүхий нефть импортлох боломжийн талаар харилцан санал солилцож санамж бичигт гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхий сайдын БНСУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт тухайлан дулааны шугам сүлжээний чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.

Швейцарийн Парламентын даргыг Монгол Улсад айлчлах үеэр алтыг мөнгөн ус, цианит натри хэрэглэхгүйгээр боловсруулах бичил уурхай байгуулах төслийн санамж бичигт гарын үсэг зурав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт:

“Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай 2007 оны 96 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын Төсвийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэв.

“Хүнсний буудайн нөөц бүрдүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барив.

“Хүнсний буудайн нөөц бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зарим хэсгийг хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, худалдах, нөхөн бүрдүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг боловсруулав.

ХХААХҮЯ-ны бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч ЗГХЭГ-т хүргүүлэв.

Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн статус, санхүүгийн талаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан яамдаас санал авахаар хүргүүлээд байна.

2008-2009 оны мал өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, цаашид авах арга хэмжээний саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Хүнсний аюулгүй байдлын жилийн ажлын явцын танилцуулга, төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулав.

“Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл боловсруулж, үзэл баримтлалыг батлуулахаар ХЗДХЯ, Сангийн яаманд хүргүүлэв. Хуулийн төсөлд яамдаас санал авч байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авахад бэлэн болгов.

“Хөдөөгийн усан хангамж хөтөлбөр”-ийн эхний хувилбарыг боловсруулав.

“Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, ХЗДХЯ-д хүргүүлээд байна.

“Технологи дамжуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, “Түүхий эдийн биржийн тухай” хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулав.

ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийн хугацааг сунгах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны урьдчилсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, танилцуулга, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, санал авахаар яамдад хүргүүлээд байна.

Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулах ажлын хүрээнд 20 аймгийн нийгэм, эдийн засаг, бизнесийн орчны судалгаа авч, 19 аймгийн төлөөлөгчидтэй уулзаж, цаашид үйлдвэрийг хөгжүүлэх талаар санал солилцож, авах арга хэмжээний санал боловсруулж байна.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгчийн газрыг Монгол Улсад байгуулах тухай танилцуулгад санал авахаар холбогдох газруудад хүргүүлэв.

Улсын ургацын комиссын гишүүд Сэлэнгэ, Төв, Булган, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Хэнтий, Архангай, Өвөрхангай аймгуудад ажиллаж, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлснээр ургац хураалтын ажлыг 10 дугаар сарын 15-нд дуусгалаа.

Энэ оны ургац хураалтын урьдчилсан дүнгээр 200.2 мянган тонн үр тариа, 144.0 мянган тонн төмс, 81.6 мянган тонн хүнсний ногоо, 12.5 мянган тонн малын тэжээлийн ургамал хурааж авсныг өнгөрсөн жилтэй харьцуулахад үр тариа 85.4 мянган тонн, төмс 30.4 мянган тонн, хүнсний ногоо 2.5 мянган тонноор тус тус нэмэгдэж, жилийн хэрэгцээт буудайны 50.0 хувь, төмсний 100 хувь, хүнсний ногооны 50,0 хувийг тус тус дотоодын ургацаар хангах боломжтой болсон байна.

“Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Улсын ургацын баярыг 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод зохион байгуулав. Ургацын баярт Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр оролцож, атрын аяны хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэл хийв. Энэхүү арга хэмжээнд тариалан бүхий 11 аймгаас 500 шахам тариаланчид оролцлоо.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанаас Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан, Говьсүмбэр аймгийн Малахын тал, Говь-Алтай аймгийн Аргалант, Завхан аймгийн Багахайрханы аймаг дундын отрын бэлчээрийн төлөв байдалд үнэлгээ дүгнэлт гаргаж, бэлчээрийн даацтай уялдуулан 2008-2009 онд өвөлжүүлж, хаваржуулах малын тоо, толгойг тогтоолоо.

Говь-Алтай аймгийн Аргалантын отрын бүс нутагт 60,0 мянган мал, Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт 250.0 мянган мал, Говьсүмбэр аймгийн Малахын отрын бүс нутагт 15.0 мянган мал, Завхан аймгийн Багахайрханы отрын бүс нутагт 30.0 мянган мал, нийтдээ 355.0 мянган мал өвөлжүүлэх хуваарь гаргаж сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан, оторчдыг хүлээн авах бэлтгэл ажил хийгдэж байна.

Говь-Алтай аймгийн Аргалантын отрын нутагт тэжээлийн таримал тариалах 15 га талбай, Завхан аймгийн Багахайрханы отрын бүс нутагт хадлангийн 25 га талбайг хашиж хамгаалах ажлыг гүйцэтгэсэн "Алтайн дээж", "Бор азрага" хоршоодын ажлын гүйцэтгэлийг гэрээний дагуу газар дээр нь шалгаж хүлээн авлаа.

2008 оны намрын ургац хураалтын үеэр газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас зээлийн өр барагдуулах, хүнсний болон үрийн улаанбуудайн нөөц бүрдүүлэх ажлын хэсэг Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Төв, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Хэнтий аймгуудын сумдаар ажиллаж урьдчилсан байдлаар 2,0 тэрбум төгрөгийн өр авлага барагдуулаад байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас элеватор, агуулахын хүрэлцээ хангамжийн байдалд судалгаа хийж өөрийн харъяа элеваторуудаас гадна Булган, Дархан-Уул аймгийн гурил тэжээлийн үйлдвэртэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, Улсын мэргэжлийн хяналтын газар, МХАҮТанхимын хөндлөнгийн хяналтын дор үрийн шинжилгээ хийлгэн ариутгуулах арга хэмжээ авч, 2008 оны 10-р сарын 28-ны байдлаар Хөтөл салбарт 12300 тонн, Сэлэнгэ салбарт 13200 тонн, Булган гурил тэжээлийн үйлдвэрт 2300 тонн стандартын шаардлага хангасан сайн чанарын буудай нөөцлөх ажлыг зохион байгуулж байна.

Япон Улсын 2007 оны санхүүгийн жилийн буцалтгүй тусламжийн хүрээнд хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх КР-1 төслийн хүрээнд 10270 тонн улаан буудай, Монгол-Оросын Засгийн газар хоорондын санамж бичгийн дагуу ОХУ-аас 94943,2 тонн улаанбуудайг тус тус хүлээн аваад байна.

20 морины хүчтэй 230 ширхэг бага оврын тракторыг хадлангийн зориулалт бүхий дагалдах тоног төхөөрөмжийн хамт хүлээн авч Ховд, Сүхбаатар, Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ аймгуудын агропаркад 115, иргэд аж ахуйн нэгжид 115 ширхэгийг тус тус хуваарилан олгов.

“Монголд үйлдвэрлэл хөгжүүлэе” төслийн хоёр дахь үе шатыг эхлүүлэх гэрээнд ХХААХҮ-ийн сайд, НҮБ-ын ХХ-ийн суурин төлөөлөгч нар гарын үсэг зурав.

Арьс ширний салбарын 4 стандартыг шинээр батлуулах, 1 стандартыг шинэчлэхээр төсөл боловсруулан, Техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж, Үндэсний Зөвлөлд хэлэлцүүлэхээр хүргүүлэв.

Модны үйлдвэрлэлийн стандартчиллын техникийн хорооны шинэчилсэн бүрэлдэхүүнийг тохиролцож, одоо мөрдөгдөж байгаа болон 2008-2009 онуудад батлуулах шаардлагатай стандартуудын судалгааг гаргав.

Түүхий эдийн экспортод тогтоосон стандарт, техникийн зохицуулалтын мөрдүүлэлтэнд хяналт тавих талаар холбогдох байгууллагуудтай хамтарсан уулзалт зохион байгуулж, уулзалтаас гарсан санал, уулзалтын тэмдэглэлийг Шадар сайдын ажлын албанд хүргүүлэв.

Арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хаягдал ус цэвэрлэх байгууламжийн засвар үйлчилгээг үйлдвэрүүдийн оролцоотой хийж гүйцэтгэн хэвийн жигд ажиллагааг хангах зорилгоор Нийслэлийн ЗАА-тай хамтарсан Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Мөн боловсруулах үйлдвэрүүдийг цэвэр усаар хангах, хаягдал ус цэвэрлэх үйлчилгээний үнэ тариф нэмэгдсэнтэй холбогдуулан УСУГ-тай хамтарсан уулзалт зохион байгуулж, 2009 оны 1-р сарын 1 хүртэл үйлчилгээний үнэ тарифыг 50%-иар хөнгөлөхөөр боллоо.

“Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2008 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж, уг арга хэмжээнд яамны газар, хэлтэс, харьяа 20 гаруй байгууллага, аж ахуйн нэгжүүд болон салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй гадаадын төсөл, хөтөлбөрийн 10 гаруй нэгж үйл ажиллагаагаа сурталчилсан үзүүлэн самбар гаргаж, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний жижиг үзэсгэлэн, худалдаа зохион байгуулж, гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж оролцов. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 400 гаруй иргэнд тодорхой мэдээлэл өгч, тэдний тавьсан санал, хүсэлтийг шийдвэрлэж, гарын авлага, зөвлөмжөөр хангах үйлчилгээ үзүүлэв.

Японы Ядуурлыг бууруулах сангийн хөрөнгөөр Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлэх “Ядуу малчин өрхүүдэд зориулсан уст цэг ба нэвтрүүлэх төв байгуулах төсөл”-ийг Өвөрхангай аймагт хэрэгжүүлж эхлэхээр АХБ, ХХААХҮЯ, Сангийн яам хооронд “Санамж бичиг”-т гарын үсэг зурж, төслийг эхлүүлэв.

“КОЙКА” байгууллагын шугамаар хэрэгжиж байгаа “Халх голын бүс нутагт хөдөө аж ахуйг сэргээн хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г боловсруулах төслийн эхлэлтийн семинарыг зохион байгуулав.

Монгол Улс, Япон Улсын Засгийн газар хооронд болон хөрөнгө оруулагч бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааны 2 дугаар зөвлөлгөөн манай улсад 2008 оны 10 дугаар сарын 10-нд Улаанбаатар хотод болов. Уг уулзалтад “Мал сүргийн эрүүл мэнд, махны экспорт” сэдэвт илтгэл тавьж оролцлоо.

Гадаад харилцааны салбарт:

Францын Эвиан хотноо 10 дугаар сарын 6-8-ны хооронд анх удаа зохион байгуулагдсан “Дэлхийн бодлого” бага хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Бага хурлын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр НАТО-гийн ЕНБД ноён Яп дэ Хооп Шеффер, Европын Парламентын дарга ноён Ханс Герт Поттеринг, ШХУ-ын Ерөнхийлөгч П.Кушпэн, Сербийн Ерөнхийлөгч Б.Тадич, Москвагийн ОУХДС-ийн захирал А.В.Торкунов, АНУ-ын олон нийтийн зүтгэлтэн Жесс Жаксон зэрэг хүмүүстэй тус тус уулзаж, санал солилцсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Бүгд Найрамдах Болгар Улсад 10 дугаар сарын 9-10-нд төрийн айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Болгарын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд нартай тус тус уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов. Айлчлалын хүрээнд Өр зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын санамж бичиг, Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг болон Болгарын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих агентлагийн хамтын ажиллагааны тухай санамж бичиг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын хамтын ажиллагааны тухай протокол, Монгол Улсын ГХЯ-ны Сургалт, судалгааны төв болон Болгар Улсын Гадаад хэргийн яамны дэргэдэх Дипломатын Институт хоорондын хамтын ажиллагааны тухай санамж бичиг, Монголын Антарктидийн Нийгэмлэг болон Болгарын Антарктидийн Институтын хооронд Антарктид дахь хамтын ажиллагааны тухай санамж бичиг зэрэг баримт бичигт тус тус гарын үсэг зурав.

Ерөнхий сайд С.Баярын АНУ-д хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын Байгаль орчны яам, АНУ-ын Дотоод хэргийн яамтай байгуулсан загас, ан амьтны чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурав.

Ерөнхий сайд С.Баяр 2008 оны 10 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд БНСУ-д албан ёсны айлчлал хийв. Тус айлчлалын үеэр Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын гэрээ; Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон Солонгосын Эрчим хүчний корпораци хоорондын Харилцан

ойлголцлын санамж бичиг; Хөдөлмөр эрхлэх системийн дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллах хүч илгээх тухай Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын хөдөлмөрийн яам хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг зэрэг нэр бүхий 3 баримт бичигт гарын үсэг зурав.

Туркийн Шадар сайд бөгөөд Төрийн сайд Хаяати Языжы тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад 10 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд айлчлав.

Швейцарийн Холбооны Улсын Ерөнхийлөгч А.Буньон 10 дугаар сарын 17-20-нд Монгол Улсад албан ёсоор айлчлав. Тэрээр Ерөнхийлөгч Н.Энхбаяр, УИХ-ын дарга Д.Дэмбэрэл, Гадаад харилцааны дэд сайд Б.Энхмандах нартай тус тус уулзаж, Швейцарийн албан ёсны тусламжийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаатай танилцав. Швейцарийн тал 2012 он хүртэл жил бүр 9 сая орчим швейцарь франкийн тусламж үзүүлэх болсныг албан ёсоор мэдэгдэв.

Монгол Улс- Европын Холбооны Хамтарсан хорооны 11 дүгээр хуралдаан Улаанбаатарт амжилттай болж, хоёр тал Хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав. Европын Холбооны Гурвалсан дарга /Тройка/ нарын айлчлалыг зохион байгуулав. Тройка-гийн төлөөлөгчдийг УИХ-ын дарга, Гадаад харилцааны сайд нар тус тус хүлээн авч уулзав.

Фридрих-Эбертийн сангийн ЗХА-ийн асуудлыг хариуцсан төлөөлөгч ноён Шверсенски 9 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 3-ны хооронд Улаанбаатарт ажиллах үеэрээ УИХ-ын дарга Д.Дэмбэрэл, УИХ-ын Төрийн байгуулалтын БХ-ны дарга Ө.Энхтүвшин нартай уулзав.

Шведийн Элчин сайд М.Линдстром 9 дүгээр сарын 23-ны өдөр Гадаад харилцааны сайд С.Батболдтой уулзаж, энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийг 2009-2010 онд Хойд Европын улсуудад айлчлуулах талаар санал тавьж ярилцав. Хууль бусаар цагаачлагч иргэдийг буцаан авах талаар хэлэлцээр байгуулах асуудлаар Шведийн талаас санал тавьсныг холбогдох байгууллагуудад уламжлав.

Гадаад харилцааны сайд С.Батболд Туркийн Элчин сайд А.А.Аraryг хүлээн авч уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа, мөн Туркийн Ерөнхий сайдын айлчлалын асуудлаар санал солилцов.

Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНЛитваУ-аас Монгол Улсад суух Элчин сайд Р.Бертонасыг ИЖБ-ээ барьсантай нь холбогдуулан хүлээн авч уулзав.

Гадаад харилцааны сайд С.Батболд Австрийн Элчин сайд М.Сайдикийг хүлээн авч уулзан, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар санал солилцов.

Нидерландын Элчин сайд Рудольф Симон Бэкинк ИЖБ-ээ барив.

Норвегийн Элчин сайд С.Сайтер ИЖБ-ээ барьж, тэрээр Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Гадаад харилцааны дэд сайд нартай уулзав.

БНСан Марино Улсаас Монгол Улсад суух Элчин сайд Р.ди Серио ИЖБ-ээ барив.

Бүгд Найрамдах Кипр Улсын Элчин сайд ИЖБ-ээ барив. ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Элчин сайдыг хүлээн авч, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Ерөнхий сайдын зөвлөх К.Сайраан нар Казахстаны Элчин сайд О.Нурбаевыг тус тус урьж уулзан, Монгол, Казахстаны хамтарсан хөрөнгө оруулалтын сан байгуулах, Казахстангаас түүхий нефть, нефтийн бүтээгдэхүүн авах тухай, Евразийн хөгжлийн банканд элсэн орох боломжийн талаар санал солилцов.

Монгол-Израилийн Гадаад хэргийн яамдын зөвлөлдөх уулзалтыг 9 дүгээр сарын 23-нд ГХЯ-нд зохион байгуулав.

Кубын шинэ Элчин сайд 9 дүгээр сарын 26-нд Монгол Улсын Ерөнхийлөгчид ИЖБ-ээ барив.

Канад Улсын шинэ Элчин сайд ИЖБ-ээ барин үүрэгт ажилдаа орсонтой холбогдуулан УИХ-ын дарга 9 дүгээр сарын 29-нд хүсэлтийнх нь дагуу хүлээн авч уулзав.

Гадаад харилцааны дэд сайд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр Канадын Гадаад харилцааны дэд сайд, АНУ-ын Төрийн департаментын Туслах нарийн бичгийн дарга нартай тус тус уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны зарим асуудлаар санал солилцов.

Кубад байгалийн гамшиг тохиолдсонтой холбогдуулан тусламж үзүүлэх тухай асуудлыг Засгийн газрын 10 дугаар сарын 14-ний хуралдаанаар хэлэлцээд Засгийн газраас 20000 ам. долларын мөнгөн тусламж үзүүлэхээр болов.

Ерөнхий сайд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд оролцож, Вашингтон хотноо хийсэн ажлын уулзалтуудын дүнг Засгийн газарт оруулахаар бэлтгэж байна. Ерөнхий сайд С.Баяр АНУ-ын Дэд ерөнхийлөгч Р.Чэйни, Конгрессын Төлөөлөгчдийн танхим дахь Монголыг дэмжих бүлгийн ахлагч Жоу Питтс, дэд дарга Жоу Уилсон, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Ерөнхийлөгч Лорн Крейнер, Үндэсний ардчилсан хүрээлэнгийн Ерөнхийлөгч Кеннет Уоллак нартай тус тус уулзав. Энэхүү ажлын айлчлалын үеэр "Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, АНУ-ын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны Санамж бичиг" байгуулагдав.

Агаарын харилцааны тодорхой асуудлын тухай Хэвтээ тэнхлэгийн хэлэлцээрийн талаар Европын Холбооны төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, хэлэлцээнд оролцож, мөн Монгол Улсын Засгийн газар, Европын Холбоо хоорондын хамтарсан хорооны хуралдаанд тус тус оролцож, Хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав.

Япон Улсад албан дипломат паспорттай иргэд визгүй зорчих хэлэлцээр байгуулах асуудлын үндэслэлийг боловсруулав.

Бүгд Найрамдах Казахстан Улс улаан буудайн экспортод тавьсан хоригоо цуцалсан тухай болон казахстаны үр тарианы компаниуд Монголд үр тариа нийлүүлэхэд бэлэн байгаа тухай мэдээллийг ХХААХҮ-ийн яам, МХАҮТ-д хүргүүлэв.

БНХАУ-тай байгуулсан Авто тээврийн тухай хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай монголын талын төслийг хятадын талд гардуулж, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар хоёр талын холбогдох яамдын мэргэжилтнүүдийн уулзалтыг энэ оны 11 дүгээр сарын сүүлчээр Улаанбаатар хотноо хийхийг санал болгов.

Батлан хамгаалах салбарт:

БНЭУ-д болох “Нүүдэлчин заан-2008” Энэтхэг-Монголын цэргийн тусгай хүчний хамтарсан хээрийн сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс цэргийн баг оролцуулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.

Түүнчлэн Засгийн газрын 1998 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэн цэргийн албыг хаах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, УИХ-ын 1998 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаах болзол”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

Яам, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөний тодотголд тулгуурлан тодотгох, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг даалгаваржуулахад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөнд улсын эдийн засаг, нийгмийн бүх салбар дахь гол үзүүлэлтүүдийг 2006 оны статистикийн мэдээлэлтэй харьцуулан дүгнэлт хийх ажлыг эхлүүлэх, шаардлагатай мэдээллийг холбогдох яамдаас авах ажил хийгдэж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын БХЯ-ны төлөөлөгчдийн Токиогийн 13 дахь чуулга уулзалтад батлан хамгаалах яамны төлөөлөгчид оролцлоо.

Батлан хамгаалах яамны “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 10 дугаар сарын 13-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. “Нээлттэй хаалганы өдөр”-т БХЯ, ЗХЖШ-аас гадна Улаанбаатар цэргийн хүрээний бүх анги, байгууллагын цэргийн болон энгийн албан хаагчид оролцож, арга хэмжээнд давхардсан тоогоор 10000 шахам иргэд хүрэлцэн ирж сонирхон, батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, бодлого зорилттой танилцлаа.

НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцогч цэргийн албан хаагчдад зориулсан 50 айлын орон сууцыг 1 330.0 сая төгрөгөөр барьж, ашиглалтанд оруулан, энхийг сахиулагч нарт хүлээлгэн өглөө.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ЗХЖШ-ын төлөвлөгөөнд тусгагдсан цэргийн дэд төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэлт хийж, ЗХЖШ-ын удирдлагад танилцуулав.

“Иргэнийг гэрээт цэргийн албанд элсүүлэх журам”-ын дагуу 8 иргэнийг гэрээт цэргийн албанд элсүүлж, 2008 оны 2 дугаар ээлжийн цэрэг татах, 2007 оны 2 дугаар ээлжээр цэргийн албанд татагдан ирсэн дайчдыг халах ажлын бэлтгэлийг хангаж ажиллав.

ОХУ-аас худалдан авсан Ми-171 Е загварын олон зориулалтын нисдэг тэргээр нислэг үйлдэх бэлтгэлийг хангах ажлын хүрээнд “Улсын бүртгэлийн гэрчилгээ”, “Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ”-ний загварыг боловсруулан батлуулж, шалгалтын нислэгийн гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Сиерра Леон Улсад НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй 6 дугаар ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн болон Баруун Сахар, Судан, Этиоп, Гүржид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний 9 офицер цэргийн ажиглагчийн үүргээ хэвийн гүйцэтгэж байна.

АНУ-ын Номхон далай дахь Тэнгисийн цэргийн командлалтай хамтран мэргэжилтнүүдийн туршлага солилцох семинарыг Зэвсэгт хүчний 6 анги, байгууллагын 20 офицерыг хамруулан 330 дугаар ангид зохион байгуулж байна.

Хууль, эрх зүйн салбарт:

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн дүйцүүлэх албыг иргэн мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг шинэчлэх тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай зэрэг нийт 7 хуулийн төслийн болон УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалуудыг хянаж, холбогдох яамтай хамтран баталлаа.

Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв байгуулах тухай, Байгаль орчны төрийн бус байгууллагуудын улсын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулах тухай, “Нүүдэлчин заан-2008” хамтарсан сургалт, дадлагад цэргийн баг оролцуулах тухай, Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хооронд 2009-2011 онд хамтран ажиллах соёлын солилцооны хөтөлбөрийн төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Ерөнхий сайдын захирамжийн төсөлд санал авах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай зэрэг Засгийн газрын шийдвэрийн 46 төсөлд санал өгсөн.

Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай Засгийн газрын тогтоолын 7 төсөлд санал өгөв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 13 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2008 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг “Нээлттэй хаалганы өдөр” болгон тус яам болоод харъяа агентлагийн төлөөлөл оролцсон нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулав.

Энэ өдөр яамны газар, хэлтэс, харъяа агентлаг, байгууллагуудын хэмжээнд иргэдэд зориулсан үйлчилгээг нэг цэгээс үзүүлэн ажиллав. Үүнд: иргэний бүртгэл, мэдээллийн ажилтнууд иргэний үнэмлэх болон гадаад паспортын үйлчилгээ, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн албанаас зөвшөөрөл, визийн үйлчилгээний талаар мэдээлэл, гарын авлага тараасан бөгөөд Хууль зүйн үндэсний төвөөс хууль зүйн зөвлөгөө өгч, хорих ангид ял эдэлж буй хүмүүстэй ар гэрийнхнийг нь утсаар яриулж, арга хэмжээний үеэр давхардсан тоогоор нийт 1603 иргэнд үйлчиллээ. Мөн Нотариатын танхимын нотариатч нар иргэдэд үнэ төлбөргүй үйлчилж, Өмгөөлөгчдийн холбоо хууль зүйн зөвлөгөө өглөө.

Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт нийт 11-ийг хянаж, улсын бүртгэлд 8-ыг бүртгэж, 2-т дүгнэлт өгч, нэгийг буцаасан болно.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл 16, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 2, шашны байгууллага 10, төрийн бус байгууллага 67-г улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгов.

Албан болон хувийн хэргээр түр буюу удаан хугацаагаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлтийг үндэслэн орох 814, орох гарах 9, олон удаагийн 89, нийт 912 гадаадын иргэнд олгох визийн зөвшөөрлийг Гадаад хэргийн яамны консулын газарт өгч, гарах-орох 468, гарах 4121, олон удаагийн 1 жилийн 297, 6 сарын 120, нийт 5006 виз олгосон.

Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, бүртгэл, хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болон визийн хугацаа хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан гадаадын 27 орны 448 иргэнд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авч, 81 сая 900 мянган төгрөгийг, Гадаадын орнуудаас урьсан иргэнээ зохих хугацаанд бүртгүүлээгүй, хууль бусаар хөдөлмөр эрхлүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн, нуун далдалсан зэрэг зөрчлийн улмаас 91 байгууллага, аж ахуйн нэгжид /116 гадаадын иргэнд/ Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу арга хэмжээ авч, 73 сая 100 мянган төгрөгийг, нийт 155 сая төгрөгийг тус тус улсын орлогод оруулсан байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР